

## Ажлын хэсэг байгуулах тухай

Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.1.3-ийн “а”, 29.2, Гамшгаас хамгаалах тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.1.1, Эрүүл мэндийн тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.2.1 дэх заалт, Нийслэлийн Онцгой комиссын 2020 оны 01 дүгээр сарын 25-ны өдрийн 2 дугаар хуралдааны шийдвэрийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. Томуу, томуу төст өвчний тархалт, шинэ коронавирусийн халдвараас урьдчилан сэргийлэх чиглэлээр шуурхай арга хэмжээ авч ажиллах, үүрэг бүхий Ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Дарга: С.Эрдэнэбаяр Дүүргийн Онцгой байдлын хэлтсийн дарга,

Урьдчилан сэргийлэх, хариу арга хэмжээ авах дэд хэсэг:

Дарга	Ц.Лхагва	Дүүргийн Эрүүл мэндийн төвийн дарга
Гишүүд:	О.Нямбат	Засаг даргын Тамгын газрын Төрийн захиргааны удирдлагын хэлтсийн дарга
	Я.Орломсүрэн	Засаг даргын Тамгын газрын Нийгмийн хөгжлийн хэлтсийн дарга
	Ж.Байгаль	Дүүргийн Боловсролын хэлтсийн дарга
	Х.Азбаяр	Дүүргийн Гэр бүл, хүүхэд залуучуудын хөгжлийн хэлтсийн дарга
дарга	Н.Ганчимэг	Дүүргийн Улаан загалмайн хорооны дарга

Хяналт шалгалтын ажлын дэд хэсэг:

Дарга:	Д.Хишигбаатар	Дүүргийн Мэргэжлийн хяналтын хэлтсийн дарга
Гишүүд:	Б.Шинэбаатар	Дүүрэг дэх Цагдаагийн газрын дарга
	Д.Ганболд	Дүүргийн Замын цагдаагийн хэлтсийн дарга
	Ч.Мөнгөнсарнай	Онцгой байдлын хэлтсийн Гамшгийн эрсдэлийн удирдлага, үнэлгээ хариуцсан мэргэжилтэн
Нарийн бичгийн дарга:	Х.Чинзориг	Дүүргийн Эрүүл мэндийн төвийн орлогч дарга

2. Томуу, томуу төст өвчний тархалт, шинэ коронавирусийн халдвараас урьдчилан сэргийлэх ажлын төлөвлөгөө гарган батлуулж хэрэгжилтийг ханган болзошгүй тохиолдлын үед ажиллахад шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгсэл, ариутгал халдваргүйтгэлийн бодисын нөөцийг бүрдүүлж, дүүргийн Онцгой комиссын удирдлагыг тухай бүр шуурхай мэдээллээр хангаж, санал танилцуулж хөрөнгийн асуудлыг тухай бүр шийдвэрлүүлж ажиллахыг Ажлын хэсэгт үүрэг болгосугай.

4. Захирамжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг Засаг даргын Тамгын газар /А.Дамцагдорж/-т даалгасугай.

ЗАСАГ ДАРГА

Ж.ЭРДЭНЭБАТ